



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 26

Чингис хот

Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн тухай

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.1.1, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 16, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3, 2.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн, Өмнэдэлгэр сумын иргэн Л.Баярмаагийн өргөдлийг хянан шалгасан дүгнэлтийг хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Өмнэдэлгэр сумын иргэн Л.Баярмаагийн ээлжийн амралтын нөхөн олговор олгуулах тухай өргөдлийн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд Л.Баярмаа нь Төрийн албаны тухай хуулийн 13-р зүйлийн 13.1, 13.1.1 дэх хэсэгт заасан Төрийн жинхэнэ албан хаачийн нийтлэг үүргээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Засаг даргын захирамж шийдвэргүйгээр ээлжийн амралт эдэлсэн байх тул нөхөн олговор олгох үндэслэлгүй гэж үзсүгэй.

2. Өргөдлийн хариуг албан бичгээр хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР